

**УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН
ТӨВӨӨС ИНЖЕНЕРИЙН ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГУУДААС
АВСАН САНАЛ АСУУЛГЫН ДҮН МЭДЭЭ**


2019 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Төвийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу инженерийн хангамжийн байгууллагуудын шуурхай ажиллагааны хэсгийн инженер, диспетчерүүдээс санал, асуулгыг 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр 01/204 дугаар албан бичгээр Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Ус сувгийн удирдах газар, Хэсэгчилсэн Инженерийн хангамжийн удирдах газар, Хот тохижилтын газар, Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар, Геодези, усны барилга байгууламжийн газарт тус тус хүргүүлж, авч ажилласан. Санал асуулгын хариуг 11 дүгээр сарын 05-наас 11 дүгээр сарын 29-ний өдрүүдэд албан бичиг болон цахим хаягаар хүлээн авч дүнг нэгтгэн ажилласан. Улаанбаатар Зам засвар, арчлалтын газраас санал асуулгын хуудсыг ирүүлээгүй болно. Санал асуулгад нийт 6 байгууллагаас 67 албан хаагчид хамрагдсан.

Байгууллагаар ангилан харуулбал:

№	Байгууллагууд	Хамрагдсан албан хаагчдыг тоо
1	Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК	20
2	Ус сувгийн удирдах газар	11
3	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар	19
4	Хэсэгчилсэн инженер хангамжийн удирдах газар	4
5	Хот тохижилтийн газар	2
6	Геодези, усны барилга байгууламжийн газар	11
Нийт		67




Асуулт 1: Та манай төвтэй өдөр тутам холбогдож ажилладаг уу?

- а) Тийм - 34 /50.74%/
- б) Үгүй -9 /13.43%/
- в) Зарим тохиолдолд – 24 /35.82%/

Асуулт 2: Манай төвд хандсанаар таны ажлыг хөнгөвчилж чадаж байгаа эсэх?

- а) Маш сайн - 13 /19.4%/
- б) Сайн - 28 /41.79%/
- в) Дунд – 17 /25.37%/
- г) Нөлөөлдөггүй - 5 /7.46%/
- д) Бөглөөгүй-4 /5.97%/




Асуулт 3: Мэдээллийг үнэн зөв, шуурхай өгч байгаа эсэх?

- а) Тийм - 56 /83.58%/
- б) Үгүй - 8 /11.94%/
- в) Заримдаа – 1 /1.49%/
- г) Бөглөөгүй - 2 /2.98%/

Асуулт 4: Шуурхай ажиллагааны үед оновчтой арга хэмжээ авч зохицуулалт хийсэн байдал?

- а) Маш сайн - 7 /10.44%/
- б) Сайн - 41 /61.19%/
- в) Дунд - 16 /23.88%/
- г) Огт зохицуулдаггүй – 1 /1.49%/
- д) Бөглөөгүй - 2 /2.98%/



Асуулт 5: Та манай төвийн 310005 утсанд хандаж зохицуулалт хийлгэхээр хандаж байсан бол шийдвэрлэлтийн байдалд сэтгэл ханамжтай байсан уу?

- а) Ханамжтай - 40 /59.7%/
- б) Дунд зэрэг - 18 /26.86%/
- в) Ханамжгүй - 5 /7.46%/
- г) Бөглөөгүй - 4 /5.97%/

Асуулт 6: Диспетчер-инженерүүд харьцааны зааврын дагуу харьцаж байгаа эсэх?

- а) Тийм - 55 /82.08%/
- б) Үгүй - 7 /10.44%/
- в) Бөглөөгүй - 5 /7.46%/

Асуулт 7: Цаашид ямар асуудалд анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна? гэсэн хэсэгт нийт судалгаанд хамрагдсан 67 албан тушаалтнаас 22 нь буюу 32.8% нь санал сэтгэгдлээ бичсэн байна.

Байгууллага болгоноор нь тодруулж харуулбал:

Ус сувгийн удирдах газар:

- Хамтран ажиллахад таатай асуудлыг шуурхай шийдвэрлэж өгдөгт баярладаг шүү. Ажлын амжилт.
- Цаашид инженерийн хангамжийн байгууламжуудын ажлын уялдаа холбоо сайжруулж ажиллах

- Харьцааны зааврын дагуу хамтран ажилладаг байдлаа хадгалж ажиллах.
- Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК:
- Гэрэлтүүлэг болон холбооны утас, шонг манай байгууллагатай андуурч дуудлага авдаг. Ялгаж салгах.
 - Хог хаягдал, гэрэлтүүлэг, далан суваг, кабель шугамын засварын ажилд хяналт тавьж ажиллах.
 - Яаралтай онцгой дуудлага биш бол бусад дуудлагыг 70047004 дугаар луу өгүүлэх.

Хэсэгчилсэн Инженерийн хангамжийн удирдах газар:

- Инженерийн хангамжийн байгууллагуудад гарсан аваар саатлын үед зохицуулалт хийсэн дүн мэдээг урьдчилан сэрэмжлүүлэх үүднээс цахим байдлаар танилцуулж ажиллах.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар:

- Зан харьцаа тааруу /Болормаа/
- Цаашид иргэдийн санал, гомдлыг 70005454 утсаар авна гэж иргэдэд мэдээлэл өгмөөр байна. /Сувд/
- УСУГ, ДШС, ЦШС-тэй холбоотой гомдлыг шуурхай шийдэж өгмөөр байна. /Мөнхжаргал/
- Хувийн ОСК-той холбоотой ирсэн гомдлыг шуурхай төв шийдвэрлэхгүй байна гэсэн гомдол ирж байна, цаашид анхаарах.

Хот тохижилтийн газар:

- Замын тэмдэг тэмдэглэгээ, хайс хашлага эвдэрч гэмтэхэд яаралтай арга хэмжээ авч байгаа нь сайн байна.
- Авто замын хайс хашлага, хайрга шороо асгарсан байдал, гэрэлтүүлэг өглөөгүүр муу асаж байна.

Геодези, усны барилга байгууламжийн газар:

- Байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.
- Аливаа ажлын нэр байршилыг шалгаж, холбогдох байгууллагуудад шуурхай мэдэгдэж, хяналт тавьж ажиллах
- Харилцаа холбоог улам бэхжүүлэх, мэдээ мэдээллийг түргэн шуурхай солилцох, туршлага солилцох
- Мэдээллийг үнэн зөв өгөх

Цаашид анхаарах асуудал:

Санал асуулгаар Мэдээллийн үнэн зөв, шуурхай өгч байгаа эсэх? гэсэн асуулгад 56 албан тушаалтан тийм буюу 83.58%-тай хариулт өгсөн нь өнгөрсөн онтой харьцуулахад өөрчлөлтгүй байгаа бол Диспетчер-инженерүүд харьцааны зааврын дагуу харьцаж байгаа эсэх? гэсэн асуулгад 55 албан тушаалтан тийм буюу 82.08%-тай хариулт өгсөн нь өмнөх жилтэй харьцуулахад 7%-р буурсан тул анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

Санал асуулгаас харахад дээрх байгууллагуудын албан тушаалтнууд цаашид Төвийн үйл ажиллагааг сайжруулах, бусад инженерийн хангамжийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирсэн гомдлыг харьяа байгууллагын утсанд мэдэгдэж ажиллах /зарим тохиолдолд харьяаллын бус гомдол өгч байна/, үнэн бодит мэдээлэл түгээх, инженерийн шугам сүлжээнд гарсан аваар, саатлын үед зохицуулалтыг түргэн шуурхай хийж, хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа дурдсан. Иймд дээрх саналуудыг харгалзан ажил хэрэг болгож ажиллах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН: ДАРГА

Ч.ГАН-ОЧИР

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ ДИСПЕТЧЕР

Г.ГАНЗОРИГ

ДҮН МЭДЭЭ НЭГТГЭСЭН:
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

М.БАДАМЖАВ